



МОНГОЛБАНК  
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

---

# ТӨЛБӨРИЙН СИСТЕМИЙН ТООН ҮЗҮҮЛЭЛТ /2020 оны I улирал/

---

## ТӨЛБӨРИЙН СИСТЕМИЙН ТООН ҮЗҮҮЛЭЛТ

/2020 оны I улирал/

Тайланд карт гаргагч, хүлээн авагч 13 банк, карт хүлээн авагч 1 байгууллагын төлбөрийн карт, төхөөрөмж, бусад төлбөрийн хэрэгслийн мэдээллийг нэгтгэж үзүүлэв. Картын хэрэглээг хот ба орон нутгаар, идэвхтэй болон идэвхгүй ашиглагдаж байгаа гэж ангилахаас гадна картын нэр төрлөөр (Ұ карт, Виза, Мастеркарт, ЮнионПэй, Американ Экспресс, ЖейСиБи) тус бүрт нь авч үзэв. Мөн картын үйлчилгээнд ашиглагдаж буй төхөөрөмжийн тоо (ПОС, МПОС, ПОБ, АТМ<sup>1</sup>, СДМ<sup>2</sup>, СРМ<sup>3</sup>, Цахим худалдаа, Киоск<sup>4</sup>), тэдгээрийг ашиглан хийгдсэн гүйлгээний тоо, дүнг карт гаргагч, хүлээн авагч банкаар, өөрийн болон бусад клирингийн системд хийгдсэн байдлаар ялган үзүүллээ.


Төлбөрийн системийн оролцогч хоорондын бага дүнтэй гүйлгээний Автомат клиринг хаус (АСН+) систем болон их дүнтэй гүйлгээний Банксүлжээ системээр дамжсан гүйлгээний тоо, дүнг улирлаар авч үзэн, өөрчлөлт ба нийт гүйлгээнд эзлэх хувийг тодорхойлов.

Тайлантай холбоотой тоон мэдээллийн дэлгэрэнгүйг хавсралт хэсэгт нэгтгэв.

### 1. ТӨЛБӨРИЙН КАРТЫН ХЭРЭГЛЭЭ

#### • Картын тоо

Банкуудын гаргасан картын тоо 2020 оны I улирлын байдлаар 3.7 сая ширхэг байгаа нь өмнөх оны IV улирлаас өөрчлөгдөөгүй байгаа ч өмнөх оны I улирлын үзүүлэлттэй харьцуулахад 74.5 мянган ширхэгээр буюу 2 хувиар өссөн байна. Нийт картын 44.1 хувь буюу 1.65 сая карт идэвхтэй ашиглагдаж байгааг Зураг 1-т үзүүлэв.



Идэвхтэй ашиглагдаж байгаа картын тоо өмнөх улирлаас 245.5 мянга буюу 12.9 хувиар, өмнөх оны I улирлын үзүүлэлтээс

<sup>1</sup> АТМ зөвхөн бэлэн мөнгөний зарлага хийнэ

<sup>2</sup> СДМ зөвхөн бэлэн мөнгөний орлого хийнэ

<sup>3</sup> СРМ бэлэн мөнгөний орлого, зарлага хийнэ

<sup>4</sup> ПОС төхөөрөмжтэй


105.3 мянга буюу 6 хувиар тус тус буурсан байна (Хүснэгт I). Дэлхийн улс орон даяар хурдацтайгаар тархсан “COVID-19” буюу коронавирусын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх үүднээс хөл хорио тогтоосон, үзвэр үйлчилгээний газруудын үйл ажиллагааг хязгаарласан, хэсэгчлэн хаасантай холбоотойгоор 2020 оны I улиралд нийт идэвхтэй ашиглагдаж буй картын тоо буурчээ.

Картын хэрэглээний тайлан (сая ширхэг)

| Хүснэгт I                          | 2019 он, IV улирал | 2019 он, I улирал | 2020 он, I улирал | Өсөлт/бууралт (2019-I/2020-I) |        |
|------------------------------------|--------------------|-------------------|-------------------|-------------------------------|--------|
|                                    |                    |                   |                   | Тоо                           | Хувь   |
| Картын тоо                         | 3.75               | 3.67              | 3.75              | 0.07                          | 2.03   |
| Идэвхтэй ашиглагдаж буй картын тоо | 1.90               | 1.76              | 1.65              | (0.12)                        | (5.99) |

Картын хэрэглээг аймаг, хотоор авч үзвэл 2020 оны I улирлын байдлаар орон нутагт 1.2 сая ширхэг төлбөрийн карт ашиглагдаж байгаа нь 2019 оны жилийн эцсийн үзүүлэлтээс 63.5 мянган ширхэг буюу 5.4 хувиар, өмнөх оны I улирлын үзүүлэлтээс 120.8 мянган ширхэг буюу 10.8 хувиар нэмэгдсэн байна. Хотуудын хувьд карт эзэмшигчдийн тоо 2.5 сая ширхэг байгаа нь өмнөх оны жилийн эцсийн үзүүлэлтээс 63.6 мянган ширхэг буюу 2.33 хувиар, өмнөх оны I улирлаас 46.3 мянган ширхэг буюу 1.81 хувиар тус тус буурсан байгааг Зураг 2-т үзүүлэв. Өмнөх оны I улирлын 69.5 ба 30.5

Зураг 2. Картын хэрэглээ - Орон нутаг, хотоор /сая ширхэг/



хувьтай харьцуулахад тайлант улирлын байдлаар нийт карт эзэмшигчдийн 66.9 хувь нь хот, 33.1 хувь нь хөдөө орон нутгийн иргэд байгаа нь хөдөө орон нутаг дахь карт эзэмшигчдийн хувь нэмэгдсээр байна (Хүснэгт II).


Картын хэрэглээний тайлан Өссөн дүнгээр

| Хүснэгт II |               | 2019 он, I улирал | 2020 он, I улирал | Өсөлт/бууралт |        |
|------------|---------------|-------------------|-------------------|---------------|--------|
|            |               |                   |                   | Тоо           | Хувь   |
| Картын тоо | Хотууд        | 2,554,280         | 2,507,951         | (46,329)      | (1.81) |
|            | Бусад аймгууд | 1,119,073         | 1,239,916         | 120,843       | 10.80  |

Банкуудын зүгээс техник технологийн дэвшлийг ашиглаж, үйлчилгээний шинэ төрөл, хэлбэрийг нэвтрүүлснээр санхүүгийн байгууллагын үйлчилгээг карт эзэмшигчид хүргэх боломж нэмэгдэж байгаа нь хөдөө, орон нутагт амьдарч буй иргэдийн картын тоо өсөх шалтгаан болж байна.



Банкууд 6 төрлийн картыг өөрийн банкны оноосон нэрээр гаргаж байгаа ба эдгээрийн тоо хэмжээг төрөл тус бүрээр нь Хүснэгт 16-д үзүүлэв. Тайлант хугацаанд 2.6 сая




ширхэг буюу нийт картын 69.3 хувийг үндэсний брэнд ₮ карт, 19 хувийг ЮнионПэй карт, 10.4 хувийг Виза карт тус тус эзэлж байна. Харин Мастеркарт, Американ Экспресс болон ЖейСиБи картууд хамгийн бага буюу 0.1-ээс 1 хувийг эзэлж байгааг Зураг 3-т үзүүлэв. Эдгээр үзүүлэлтийг өмнөх оны I улирлын үзүүлэлттэй харьцуулахад ₮ картын тоо 8.2 хувиар, Амекс картын тоо 33.1 хувиар, Мастеркартын тоо 2 хувиар тус тус буурсан. Тайлант хугацаанд ЖейСиБи картын тоо 404.8 хувиар, ЮнионПэй картын тоо 53.2 хувиар, Виза картын тоо 16.7 хувиар өмнөх оны үзүүлэлтээс тус тус нэмэгдсэн байна. ЖейСиБи картын тоо өмнөх оны үзүүлэлтээс хэт өсөлттэй байгаа нь Төрийн банк ЖейСиБи-тэй байгуулсан гэрээний биелэлтээ хангахын тулд

нөхцөлийг хөнгөлсөн борлуулалтыг дэмжих аян зарлан тус картыг их хэмжээгээр борлуулсантай холбоотой.

#### • Төхөөрөмжийн тоо

Өмнөх оны I улиралд төхөөрөмжийн тоог 5 нэр төрлөөр ангилж бүртгэж байсныг өөрчилж, 2019 оны IV улирлаас эхлэн шинэ зааврын дагуу төхөөрөмжийн тоог 4 төрлөөр нэмж, нийт 9 төрлөөр бүртгэдэг болсон. Үүнд ПОС, МПОС, ПОБ, АТМ, CDM, CRM, Цахим худалдаа болон Киоск төхөөрөмжүүд багтана. Нийт төхөөрөмжийн 87.2 хувийг ПОС, 4.1 хувийг МПОС, 1.8 хувийг АТМ эзэлж байгаа бол бусад төхөөрөмжүүд 0.1- 2.1 хувийг тус тус эзэлж байгааг Зураг 4-д үзүүлэв.



Орон даяар хэрэглэгдэж буй нийт төхөөрөмжийн тоог өмнөх улиралтай харьцуулахад 2.6 мянган ширхэг буюу 3.8 хувиар нэмэгдэж, 71.6 мянган ширхэг болсон (Хүснэгт 2б). Үүнийг өмнөх оны I улиралтай харьцуулахад 19.3 мянган ширхэг буюу 36.9 хувиар өсчээ.


Төхөөрөмжийн тоог хот, аймаг тус бүрээр харьцуулж үзэхэд улсын хэмжээний нийт төхөөрөмжийн 22.7 хувь нь хөдөө орон нутагт, 77.3 хувь нь Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотод байршиж байгаа нь хүн амын төвлөрөлтэй холбоотойгоор төлбөрийн картын хэрэглээ хотуудад төвлөрсөн хэвээр байгааг харуулж байна (Хүснэгт 2а).

### • Гүйлгээний тоо, дүн

Банкууд өөрийн гаргасан картаар өөрийн банкны сүлжээ, ҮЦГТ-ийн нэгдсэн сүлжээ болон гадаад сүлжээнд гүйлгээ хүлээж авч

байгаагаас 4.9 их наяд төгрөгийн 68.7 сая ширхэг буюу нийт картын гүйлгээний 66 хувийг, нийт дүнгийн 58.3 хувийг үндэсний брэнд ₮ карт, ЮнионПэй карт нийт гүйлгээний 20.6 хувь, дүнгийн 20.6 хувийг, Виза карт нийт гүйлгээний 12.5 хувь, дүнгийн 20.2 хувийг эзлэж байна. Харин Мастеркарт, Американ экспресс болон ЖейСиБи картууд харьцангуй бага буюу гүйлгээний 0.1-0.8, нийт дүнгийн 0.04-0.70 хувийг тус тус эзэлж байгааг Зураг 5-д үзүүлэв.

Зураг 5. Өөрийн гаргасан картыг бүх сүлжээнд хүлээж авсан нийт гүйлгээнд эзлэх хувь /Картын төрлөөр/



Төлбөрийн системийн оролцогчид өөрийн гаргаснаас гадна дотоодын бусад байгууллагын, гадаад байгууллагын гаргасан картыг өөрийн сүлжээнд карт уншигч төхөөрөмжөөр дамжуулан хүлээн авдаг. Тайлант хугацаанд нийт 8.2 их наяд төгрөгийн 100.3 сая ширхэг гүйлгээг амжилттай хүлээн авсан нь өмнөх жилийн эцсийн үзүүлэлтээс 20.4 ба 11.1 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна (Хүснэгт III).

Өөрийн, дотоодын бусад байгууллагын, гадаад байгууллагын гаргасан картыг өөрийн сүлжээнд хүлээн авсан амжилттай гүйлгээний тайлан - Төхөөрөмжийн төрлөөр (бэлэн, бэлэн бус) мянган ширхэг, тэрбум төгрөг


| Хүснэгт<br>III    | Бэлэн бус  |          |         |         |                   |         |            |          |                    |        |
|-------------------|------------|----------|---------|---------|-------------------|---------|------------|----------|--------------------|--------|
|                   | ПОС        |          | МПОС    |         | Цахим<br>худалдаа |         | АТМ/CRM    |          | КИОСК<br>(пос-гой) |        |
|                   | Тоо        | Дүн      | Тоо     | Дүн     | Тоо               | Дүн     | Тоо        | Дүн      | Тоо                | Дүн    |
| 2019-IV<br>улирал | 80,285.65  | 2,005.78 | 81.99   | 1.37    | 290.73            | 13.04   | 4,937.45   | 3,188.31 | 73.20              | 2.22   |
| 2020-I<br>улирал  | 73,542.65  | 1,777.24 | 39.91   | 0.90    | 327.25            | 27.18   | 3,909.75   | 2,221.41 | 76.39              | 2.20   |
| Өөрчлөлт          | (6,743.00) | (228.54) | (42.08) | (0.47)  | 36.52             | 14.14   | (1,027.69) | (966.91) | 3.18               | (0.02) |
| Өөрчлөлт<br>%     | -8.40%     | -11.39%  | -51.32% | -34.27% | 12.56%            | 108.49% | -20.81%    | -30.33%  | 4.35%              | -0.86% |

| Бэлэн   |        |         |         |                 |          |                |          | Нийт        |            |
|---------|--------|---------|---------|-----------------|----------|----------------|----------|-------------|------------|
| ПОС     |        | ПОБ     |         | АТМ/CRM зарлага |          | CDM/CRM орлого |          |             |            |
| Тоо     | Дүн    | Тоо     | Дүн     | Тоо             | Дүн      | Тоо            | Дүн      | Тоо         | Дүн        |
| 171.51  | 7.22   | 421.11  | 119.38  | 20,855.23       | 2,835.85 | 5,793.92       | 2,175.95 | 112,910.77  | 10,349.12  |
| 136.89  | 6.58   | 370.61  | 91.18   | 16,679.51       | 2,322.29 | 5,252.02       | 1,786.99 | 100,334.98  | 8,235.98   |
| (34.61) | (0.64) | (50.50) | (28.20) | (4,175.72)      | (513.56) | (541.90)       | (388.96) | (12,575.79) | (2,113.15) |
| -20.18% | -8.82% | -11.99% | -23.62% | -20.02%         | -18.11%  | -9.35%         | -17.88%  | -11.14%     | -20.42%    |

Төхөөрөмжөөр хийгдсэн нийт гүйлгээг бэлэн бус, бэлэн гэж ангилж байгаагаас, ПОС төхөөрөмжөөр хийгдсэн бэлэн бус гүйлгээний тоо хамгийн их буюу нийт бэлэн бус гүйлгээний 94.4 хувийг эзэлж байна. Гүйлгээний дүнгийн хувьд ATM/CRM төхөөрөмжөөр хийгдсэн гүйлгээний дүн нийт төхөөрөмжөөр хийгдсэн бэлэн бус гүйлгээний дүнгийн хамгийн их буюу 55.1 хувийг эзэлж байна. Бэлнээр хийгдсэн гүйлгээний тоо ба дүнгийн хувьд ATM/CRM төхөөрөмжөөр хийгдсэн гүйлгээ нийт бэлнээр хийгдсэн гүйлгээний 74.3 ба 55.2 хувийг эзэлж байна.

Гүйлгээний тоо ба дүнг төхөөрөмж тус бүрээр авч үзвэл 73.8 сая ширхэг, 1.8 их наяд төгрөгийн гүйлгээ ПОС ба Киоск төхөөрөмжөөр хийгдсэн нь 2019 оны IV улиралд хийгдсэн гүйлгээний тооноос 8.4 хувь, гүйлгээний дүн 11.4 хувиар бага байна. ATM, CDM, CRM төхөөрөмжүүдээр энэ оны I улиралд нийт 25.8 сая ширхэг, 6.3 их наяд төгрөгийн гүйлгээ хийгдсэн нь өмнөх улирлаас тооны хувьд 18.2 хувиар, дүнгийн хувьд 22.8 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байгааг Зураг 8-д үзүүлэв.

Зураг 8. Төхөөрөмжийн хэрэглээ /мянган ширхэг, тэрбум төгрөгөөр/




Тайлант улиралд ПОБ төхөөрөмжөөр нийт 91.2 тэрбум төгрөгийн 370.6 мянган гүйлгээ хийгдсэн байгаа нь өмнөх оны жилийн эцсийн үзүүлэлттэй ойролцоо байна. МПОС төхөөрөмжөөр хийгдсэн гүйлгээний тоог өмнөх улиралтай харьцуулахад 82 мянган ширхэгээс 40 мянган ширхэг гүйлгээ болж 51.3 хувиар, дүнгийн хувьд 34.3 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна. Харин Цахим худалдааны хувьд нийт 13 тэрбум төгрөгийн 290.7 мянган гүйлгээ өнгөрсөн оны IV улиралд хийгдсэн бол тайлант улиралд 27.2 тэрбум төгрөгийн 327.3 мянган гүйлгээ болж 12.6 ба 108.5 хувиар тус тус өссөн байна (Хүснэгт 4).

Сүүлийн жилүүдэд бэлэн бус төлбөрийн хэрэгсэлийн хэрэглээ нэмэгдэж байгааг картын үйлчилгээнд хамгийн өргөнөөр ашиглагдаж буй ПОС (Киоск), АТМ (CDM,

CRM) төхөөрөмжийн хэрэглээний өөрчлөлтөөр Зураг 9-д үзүүллээ. ПОС төхөөрөмжийн хэрэглээ буюу бэлэн бус төлбөрийн хэмжээ 2016 онд нийт картын гүйлгээний 43.5 хувийг эзэлж байсан бол 2017 оноос 56.1 болж нэмэгдсээр 2018 онд 65.3 хувь, 2019 онд 69.9 хувь, 2020 оны I улирлын байдлаар 73.5 хувьд хүрчээ. Харин АТМ төхөөрөмжөөр хийгдсэн гүйлгээний тоо буюу бэлэн бус мөнгийг бэлэн мөнгөнд


Зураг 9. Төхөөрөмжийн хэрэглээ - Гүйлгээний тоогоор /2016-2020 он/



хөрвүүлэх хэрэглээ 2016 онд картын нийт гүйлгээний 55.6 хувийг эзэлж байсан бол 2017 оноос буурсаар 2018 онд 33.2 хувь, 2019 онд 30 хувь, 2020 оны I улирлын байдлаар 25.8 хувь болсон байна. Энэ нь иргэд төлбөр тооцоогоо бэлэн бусаар хийх хандлага өссөөр байгааг харуулж байна (Хүснэгт 4).

ПОС (Киоск) төхөөрөмжийн хэрэглээ дүнгийн хувьд 2016 онд нийт картын гүйлгээний дүнгийн 15.4 хувийг эзэлж байсан бол 2020 оны I улирлын байдлаар 21.7 хувьд хүрчээ. Харин АТМ (СДМ, СРМ) төхөөрөмжөөр хийгдсэн гүйлгээний дүн 2016 онд нийт картын гүйлгээний 83 хувийг эзэлж байсан бол 2020 оны I улирлын байдлаар 76.9 хувь болсон байгааг Зураг 10-д үзүүлээ.

Зураг 10. Төхөөрөмжийн хэрэглээ -  
Гүйлгээний дүнгээр  
/2016-2020 он/



#### • Залилангийн гүйлгээ.

Залилангийн гүйлгээний хувьд өмнөх оны I улиралтай харьцуулахад гүйлгээний тоо 66.4 хувиар, дүн нь 274.6 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна (Хүснэгт ба,б,в). Тайлант хугацаанд нийт 233 удаагийн үйлдлээр 175.7 сая төгрөгийн залилангийн гүйлгээ хийгдсэн нь өмнөх буюу 2019 оны IV улиралтай харьцуулахад тооны хувьд 37.9 хувиар, дүнгийн хувьд 157 хувиар өссөн. Үүнд:

##### ➤ Картын төрлөөр:


1. ₮ карт 35 удаагийн үйлдлээр 7.7 сая төгрөг;
2. Виза карт 176 удаагийн үйлдлээр 151.4 сая төгрөг;
3. Мастеркарт 4 удаагийн үйлдлээр 12.4 сая төгрөг;
4. ЮнионПэй 16 удаагийн үйлдлээр 3 сая төгрөг;
5. ЖэйСиБи 2 удаагийн үйлдлээр 1.2 сая төгрөг.

##### ➤ Төхөөрөмжийн төрлөөр:

1. ПОС 68 удаагийн үйлдлээр 147.1 сая төгрөг;
2. МПОС 5 удаагийн үйлдлээр 487.1 мянган төгрөг
3. АТМ/СРМ 40 удаагийн үйлдлээр 12.2 сая төгрөг;
4. Цахим худалдаа 120 удаагийн үйлдлээр 15.9 сая төгрөгийн залилангийн гүйлгээ тус тус хийгдсэн байна (Хүснэгт ба,б,в).



Төлбөрийн систем дахь залилангийн гүйлгээг сүүлийн таван жилийн байдлаар Зураг 11-т харуулав.



## 2. ТӨЛБӨРИЙН БУСАД ХЭРЭГСЛИЙН ХЭРЭГЛЭЭ

Тайлант хугацаанд төлбөрийн бусад хэрэгслээр хийгдсэн гүйлгээний тоо, дүнг ангилж үзэхэд дараах үзүүлэлттэй байна. Банкуудын илгээсэн гүйлгээг төлбөрийн хэрэгслээр тодруулбал:

- Бэлэн мөнгө – 5.1 их наяд төгрөгийн 4.3 сая ширхэг;
- Кредит шилжүүлэг – 34.5 их наяд төгрөгийн 18.5 сая ширхэг;
- Мөнгөн гуйвуулга – 14.6 тэрбум төгрөгийн 9.1 мянган ширхэг;

- Гадаад шилжүүлэг (SWIFT) – 8.5 их наяд төгрөгийн 45.2 мянган ширхэг (Хүснэгт 5).

Харин банкуудын хүлээн авсан гүйлгээг төлбөрийн хэрэгслээр задалбал:

- Бэлэн мөнгө – 4.6 их наяд төгрөгийн 3.4 сая ширхэг;
- Мөнгөн гуйвуулга – 38.3 тэрбум төгрөгийн 26.7 мянган ширхэг;
- Гадаад шилжүүлэг (SWIFT) – 4.8 их наяд төгрөгийн 46.1 мянган ширхэг (Хүснэгт 5).

Дээрх үзүүлэлтээс үзэхэд банкн дээр хийгдэж буй харилцагчийн гүйлгээнээс шилжүүлгийн төрөл өмнөх оны үзүүлэлтийн адилаар хамгийн их буюу 70.12 хувийг эзэлж байгаа бол мөнгөн гуйвуулга дүнгийн хувьд хамгийн бага буюу нийт гүйлгээний дүнгийн 0.1 хувийг эзэлж байна.

## 3. ТӨЛБӨРИЙН СИСТЕМ ИЙН ОРОЛЦОГЧ ХООРОНДЫН ГҮЙЛГЭЭ

Төлбөрийн системийн оролцогч хоорондын гүйлгээний тооны дийлэнх хувийг бага дүнтэй гүйлгээ, дүнгийн ихэнх хувийг их дүнтэй гүйлгээ тус тус эзэлдэг харьцаа тайлант улиралд хэвээр хадгалагджээ. 2020 оны I улирлын байдлаар нийт гүйлгээний тооны 97.5 хувь буюу 12.6 сая ширхэгийг бага дүнтэй гүйлгээ, харин

нийт гүйлгээний дүнгийн 95.5 хувь буюу 64.2 их наяд төгрөгийг их дүнтэй гүйлгээ тус тус эзэлж байна (Хүснэгт 7).

Бага дүнтэй гүйлгээний тоог өмнөх оны мөн энэ үетэй харьцуулахад 127.5 сая ширхэг буюу 1 хувиар буурсан, харин их дүнтэй гүйлгээний тоо 26,000 мянган ширхэг буюу 8.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Их дүнтэй гүйлгээний дүнг өмнөх оны I улиралтай харьцуулахад 2.4 их наяд буюу 3.7 хувиар буурсан, харин бага дүнтэй гүйлгээний дүн 550.4 тэрбум буюу 22 хувиар өссөн байна. Бага дүнтэй гүйлгээний дээд хязгаарыг нэмэгдүүлж, 3 хүртэл сая төгрөгийн дүнтэй гүйлгээг бага дүнтэй системээр дамжуулах болсон нь гүйлгээний дүнгийн өөрчлөлтөнд нөлөөлсөн.

I. ТӨЛБӨРИЙН КАРТЫН ХЭРЭГЛЭЭ  
Хүснэгт 1а. Картын хэрэглээний тайлан

(Өссөн дүнгээр)

|                                    | 2019 он,<br>I улирал | 2019 он,<br>IV улирал | 2020 он,<br>I улирал | Өсөлт/бууралт |        |
|------------------------------------|----------------------|-----------------------|----------------------|---------------|--------|
|                                    |                      |                       |                      | Тоо           | хувь   |
| Картын тоо                         | 3,673,353            | 3,748,025             | 3,747,867            | 74,514        | 2.03   |
| Идэвхтэй ашиглагдаж буй картын тоо | 1,759,339            | 1,899,509             | 1,654,038            | (105,301)     | (5.99) |

|                                    |               | 2019 он,<br>I улирал | 2020 он,<br>I улирал | Өсөлт/бууралт |        |
|------------------------------------|---------------|----------------------|----------------------|---------------|--------|
|                                    |               |                      |                      | Тоо           | хувь   |
| Картын тоо                         | Хотууд        | 2,554,280            | 2,507,951            | (46,329)      | (1.81) |
|                                    | Бусад аймгууд | 1,119,073            | 1,239,916            | 120,843       | 10.80  |
| Идэвхтэй ашиглагдаж буй картын тоо |               | 1,759,339            | 1,654,038            | (105,301)     | (5.99) |

Хүснэгт 1б. Картын хэрэглээний тайлан - Аймаг, хотоор

01/01/2020 - 31/03/2020

| №                   | Хот, аймаг    | ₮ карт    |        | Виза    |        |                    |        | Мастеркарт |        |                    |        | ЮнионПэй |        |                    |        | Амекс  |        |                    |        | ЖейСиБи |        |                    |        | Нийт картын тоо |
|---------------------|---------------|-----------|--------|---------|--------|--------------------|--------|------------|--------|--------------------|--------|----------|--------|--------------------|--------|--------|--------|--------------------|--------|---------|--------|--------------------|--------|-----------------|
|                     |               | Энгийн    |        | Энгийн  |        | ₮ карттай хосолсон |        | Энгийн     |        | ₮ карттай хосолсон |        | Энгийн   |        | ₮ карттай хосолсон |        | Энгийн |        | ₮ карттай хосолсон |        | Энгийн  |        | ₮ карттай хосолсон |        |                 |
|                     |               | Дебит     | Кредит | Дебит   | Кредит | Дебит              | Кредит | Дебит      | Кредит | Дебит              | Кредит | Дебит    | Кредит | Дебит              | Кредит | Дебит  | Кредит | Дебит              | Кредит | Дебит   | Кредит | Дебит              | Кредит |                 |
| 1                   | Улаанбаатар   | 1,462,679 | 29,353 | 234,842 | 68,685 | 0                  | 0      | 16,980     | 3,237  | 11,276             | 0      | 145,310  | 8,517  | 227,299            | 45,743 | 760    | 2,797  | 0                  | 0      | 4,777   | 0      | 0                  | 0      | 2,262,255       |
| 2                   | Дархан-Уул    | 88,267    | 1,590  | 5,681   | 3,004  | 0                  | 0      | 243        | 73     | 122                | 0      | 11,067   | 146    | 8,986              | 3,095  | 233    | 11     | 0                  | 0      | 272     | 0      | 0                  | 0      | 122,790         |
| 3                   | Орхон         | 87,346    | 1,306  | 7,355   | 3,008  | 0                  | 0      | 316        | 121    | 156                | 0      | 11,447   | 197    | 8,998              | 2,107  | 139    | 32     | 0                  | 0      | 378     | 0      | 0                  | 0      | 122,906         |
| Нийт (дээрх хотууд) |               | 1,638,292 | 32,249 | 247,878 | 74,697 | 0                  | 0      | 17,539     | 3,431  | 11,554             | 0      | 167,824  | 8,860  | 245,283            | 50,945 | 1,132  | 2,840  | 0                  | 0      | 5,427   | 0      | 0                  | 0      | 2,507,951       |
| Нийт эзлэх %        |               | 64.31%    |        | 83.17%  |        |                    |        | 89.79%     |        |                    |        | 66.38%   |        |                    |        | 93.39% |        |                    |        | 57.56%  |        |                    |        | 66.92%          |
| 4.00                | Бусад аймгууд | 906,443   | 20,741 | 47,123  | 18,151 | 0                  | 0      | 2,369      | 523    | 805                | 0      | 142,378  | 1,794  | 92,222             | 3,084  | 199    | 82     | 0                  | 0      | 4,002   | 0      | 0                  | 0      | 1,239,916       |
| Нийт эзлэх %        |               | 35.69%    |        | 16.83%  |        |                    |        | 10.21%     |        |                    |        | 33.62%   |        |                    |        | 6.61%  |        |                    |        | 42.44%  |        |                    |        | 33.08%          |
| Нийт (Улс)          |               | 2,544,735 | 52,990 | 295,001 | 92,848 | 0                  | 0      | 19,908     | 3,954  | 12,359             | 0      | 310,202  | 10,654 | 337,505            | 54,029 | 1,331  | 2,922  | 0                  | 0      | 9,429   | 0      | 0                  | 0      | 3,747,867       |
| Нийт (Улс)          |               | 2,597,725 |        | 387,849 |        |                    |        | 36,221     |        |                    |        | 712,390  |        |                    |        | 4,253  |        |                    |        | 9,429   |        |                    |        | 3,747,867       |

## Хүснэгт 1в. Карт эзэмшигч - Нэр төрлөөр

2017 - 2020 он (картын тоо өссөн дүнгээр)

| Он                        | ₮ карт    | Виза    | Мастеркарт | ЮнионПэй | Амекс  | ЖейСиБи | Нийт      |
|---------------------------|-----------|---------|------------|----------|--------|---------|-----------|
| 2017 он, I улирал         | 2,801,403 | 621,150 | 14,611     | 394,801  | 12,429 | 236     | 3,844,630 |
| 2018 он, I улирал         | 3,115,568 | 680,120 | 28,379     | 457,971  | 7,307  | 1,808   | 4,291,153 |
| 2019 он, I улирал         | 2,600,808 | 392,747 | 76,255     | 664,563  | 4,464  | 9,188   | 3,748,025 |
| 2020 он, I улирал         | 2,597,725 | 387,849 | 36,221     | 712,390  | 4,253  | 9,429   | 3,747,867 |
| Өсөлт/бууралт (2020-I)    | -0.12%    | -1.25%  | -52.50%    | 7.20%    | -4.73% | 2.62%   | 0.00%     |
| Нийт зах зээлд эзлэх хувь | 69.31%    | 10.35%  | 0.97%      | 19.01%   | 0.11%  | 0.25%   | 100.00%   |

## Хүснэгт 2а. Төхөөрөмжийн хэрэглээний тайлан - Аймаг, хотоор

01/01/2020 - 31/03/2020

| №             | Хот, аймаг  | ПОС    | МПОС   | ПОБ    | АТМ    | CDM    | CRM    | Цахим худалдаа | "КИОСК (пос-той)" | Бусад | Нийт   |
|---------------|-------------|--------|--------|--------|--------|--------|--------|----------------|-------------------|-------|--------|
| 1             | Улаанбаатар | 45,227 | 2,480  | 1,254  | 802    | 34     | 1,072  | 769            | 132               | 0     | 51,770 |
| 2             | Дархан-Уул  | 1,645  | 155    | 62     | 55     | 4      | 37     | 2              | 4                 | 0     | 1,964  |
| 3             | Орхон       | 1,440  | 14     | 57     | 52     | 2      | 35     | 0              | 8                 | 0     | 1,608  |
| Нийт (Хотууд) |             | 48,312 | 2,649  | 1,373  | 909    | 40     | 1,144  | 771            | 144               | 0     | 55,342 |
| Нийт эзлэх %  |             | 77.35% | 90.22% | 55.63% | 71.80% | 86.96% | 77.09% | 98.97%         | 85.71%            | 0     | 77.28% |
| 4             | Бусад аймаг | 14,149 | 287    | 1,095  | 357    | 6      | 340    | 8              | 24                | 0     | 16,266 |
| Нийт эзлэх %  |             | 22.65% | 9.78%  | 44.37% | 28.20% | 13.04% | 22.91% | 1.03%          | 14.29%            | 0     | 22.72% |
| Нийт (Улс)    |             | 62,461 | 2,936  | 2,468  | 1,266  | 46     | 1,484  | 779            | 168               | 0     | 71,608 |

## Хүснэгт 2б. Төхөөрөмжийн тоо

2019 - 2020 он (төхөөрөмжийн тоо өссөн дүнгээр)

| №    | Төхөөрөмж         | 2019 он, I улирал | 2019 он, IV улирал | 2020 он, I улирал | Өсөлт/бууралт |         | Нийт төхөөрөмжид эзлэх хувь |
|------|-------------------|-------------------|--------------------|-------------------|---------------|---------|-----------------------------|
|      |                   |                   |                    |                   | Тоогоор       | Хувиар  |                             |
| 1    | ПОС               | 44,676            | 59,703             | 62,461            | 2,758         | 4.62    | 87.22                       |
| 2    | МПОС              | 2,679             | 2,803              | 2,936             | 133           | 4.74    | 4.10                        |
| 3    | ПОБ               | 2,231             | 2,242              | 2,468             | 226           | 10.08   | 3.45                        |
| 4    | АТМ               | 2,412             | 1,259              | 1,266             | 7             | 0.56    | 1.77                        |
| 5    | CDM* <sup>5</sup> | 0                 | 388                | 46                | (342)         | (88.14) | 0.06                        |
| 6    | CRM*              | 0                 | 1,674              | 1,484             | (190)         | (11.35) | 2.07                        |
| 7    | Цахим худалдаа*   | 0                 | 773                | 779               | 6             | 0.78    | 1.09                        |
| 8    | Киоск*            | 0                 | 163                | 168               | 5             | 3.07    | 0.23                        |
| 9    | Бусад             | 327               | 0                  | 0                 | 0             | 0       | 0                           |
| Нийт |                   | 50,333            | 69,005             | 69,005            | 2,603         | 3.77    | 100                         |

\*Төхөөрөмжийн хэрэглээний тайланд 2019 оны дөрөвдүгээр улирлаас эхлэн төхөөрөмжийн тоог 9 нэр төрлөөр бүртгэж эхэлсэн болно

Хүснэгт 3. Өөрийн гаргасан картаар нэгдсэн, гадаад сүлжээнд хүлээж авсан амжилттай гүйлгээний тайлан - Төхөөрөмжийн төрлөөр

01/01/2020 - 31/03/2020 (мянган ширхэг, тэрбум төгрөг)

| №    | Хүлээн<br>авагч<br><br>төхөөрөмж | Нэгдсэн сүлжээ |        |          |        |            |       |           |        |       |      |         |      | Гадаад сүлжээ |        |            |       |          |       |       |      |         |      | Нийт      |          |
|------|----------------------------------|----------------|--------|----------|--------|------------|-------|-----------|--------|-------|------|---------|------|---------------|--------|------------|-------|----------|-------|-------|------|---------|------|-----------|----------|
|      |                                  | ₮ карт         |        | Виза     |        | Мастеркарт |       | ЮнионПэй  |        | Амекс |      | ЖейСиБи |      | Виза          |        | Мастеркарт |       | ЮнионПэй |       | Амекс |      | ЖейСиБи |      |           |          |
|      |                                  | Тоо            | Дүн    | Тоо      | Дүн    | Тоо        | Дүн   | Тоо       | Дүн    | Тоо   | Дүн  | Тоо     | Дүн  | Тоо           | Дүн    | Тоо        | Дүн   | Тоо      | Дүн   | Тоо   | Дүн  | Тоо     | Дүн  | Тоо       | Дүн      |
| 1    | ПОС                              | 23,706.09      | 508.11 | 5,228.59 | 196.00 | 456.96     | 21.27 | 7,565.74  | 178.20 | 0.00  | 0.00 | 51.25   | 1.01 | 444.54        | 111.78 | 26.71      | 5.68  | 25.48    | 5.54  | 13.60 | 7.18 | 0.44    | 0.08 | 37,519.38 | 1,034.86 |
| 2    | ПОБ                              | 160.27         | 35.64  | 43.44    | 15.04  | 0.86       | 0.23  | 29.35     | 7.46   | 0.00  | 0.00 | 0.08    | 0.01 | 9.89          | 3.25   | 0.01       | 0.02  | 0.10     | 0.52  | 0.00  | 0.00 | 0.00    | 0.00 | 244.00    | 62.17    |
| 3    | АТМ                              | 8,330.76       | 337.04 | 1,416.01 | 78.61  | 24.66      | 3.32  | 2,655.07  | 105.58 | 0.00  | 0.00 | 7.97    | 0.93 | 94.91         | 42.57  | 3.96       | 1.88  | 18.56    | 7.44  | 0.35  | 0.43 | 0.10    | 0.06 | 12,552.33 | 577.86   |
| 4    | Цахим<br>худалдаа                | 13.57          | 0.62   | 7.49     | 0.54   | 0.36       | 0.04  | 6.33      | 0.33   | 0.00  | 0.00 | 0.01    | 0.00 | 268.09        | 50.36  | 54.51      | 7.06  | 0.37     | 0.10  | 4.69  | 1.04 | 0.04    | 0.00 | 355.44    | 60.09    |
| Нийт |                                  | 32,210.69      | 881.41 | 6,695.53 | 290.19 | 482.83     | 24.87 | 10,256.48 | 291.57 | 0.00  | 0.00 | 59.31   | 1.95 | 817.42        | 207.96 | 85.19      | 14.65 | 44.51    | 13.60 | 18.63 | 8.65 | 0.58    | 0.14 | 50,671.16 | 1,734.98 |

Хүснэгт 3б. Гүйлгээний тоо, дүн – Карт гаргагч, хүлээн авагчаар

2018 - 2020 он (мянган ширхэг, тэрбум төгрөг)

| Он                            | Утга | Карт гаргагч  |                |               | Карт хүлээн авагч |                          |
|-------------------------------|------|---------------|----------------|---------------|-------------------|--------------------------|
|                               |      | Дотоод сүлжээ | Нэгдсэн сүлжээ | Гадаад сүлжээ | Бусад банкны карт | Гадаад байгууллагын карт |
| 2018 он, I улирал             | Тоо  | 38,577.5      | 28,407.7       | 608.5         | 27,755.7          | 231.6                    |
|                               | Дүн  | 6,876.5       | 1,112.8        | 215.7         | 1,073.9           | 57.3                     |
| 2019 он, I улирал             | Тоо  | 46,411.57     | 40,597.76      | 755.88        | 39,183.29         | 256.27                   |
|                               | Дүн  | 7,397.60      | 1,429.56       | 247.94        | 1,386.69          | 57.92                    |
| 2020 он, I улирал             | Тоо  | 53,458.16     | 49,704.84      | 966.32        | 46,689.84         | 186.95                   |
|                               | Дүн  | 6,787.06      | 1,489.98       | 244.99        | 1,408.94          | 39.97                    |
| Өсөлт/бууралт хувиар (2020-I) | Тоо  | 15.18         | 22.43          | 27.84         | 19.16             | 27.05                    |
|                               | Дүн  | (8.25)        | 4.23           | (1.19)        | 1.60              | (30.99)                  |



Хүснэгт 4. Төхөөрөмж тус бүрээр хийсэн гүйлгээний дүн, тоо

2019 - 2020 он (мянган ширхэг, тэрбум төгрөг)

| №          | Төхөөрөмж      | Утга | 2019 он, I улирал | 2019 он, IV улирал | 2020 он, I улирал | Өсөлт/бууралт<br>(хувиар) |
|------------|----------------|------|-------------------|--------------------|-------------------|---------------------------|
| 1          | ПОС            | Тоо  | 54,500            | 80,457.15          | 73,679.54         | (8.42)                    |
|            |                | Дүн  | 1,488.33          | 2,013.00           | 1,783.82          | (11.38)                   |
| 2          | МПОС           | Тоо  | 100               | 81.99              | 39.91             | (51.32)                   |
|            |                | Дүн  | 1.81              | 1.37               | 0.90              | (34.27)                   |
| 3          | ПОБ            | Тоо  | 500               | 421.11             | 370.61            | (11.99)                   |
|            |                | Дүн  | 122.75            | 119.38             | 91.18             | (23.62)                   |
| 4          | АТМ/CRM/CDM    | Тоо  | 25,500            | 31,586.59          | 25,841.29         | (18.19)                   |
|            |                | Дүн  | 6,002.61          | 8,200.12           | 6,330.69          | (22.80)                   |
| 5          | Цахим худалдаа | Тоо  | 0                 | 290.73             | 327.25            | 12.56                     |
|            |                | Дүн  | 0                 | 13.04              | 27.18             | 108.49                    |
| 6          | Киоск          | Тоо  | 0                 | 73.20              | 76.39             | 4.36                      |
|            |                | Дүн  | 0                 | 2.22               | 2.20              | (0.90)                    |
| 7          | Бусад          | Тоо  | 0                 | 0                  | 0                 | 0                         |
|            |                | Дүн  | 0                 | 0                  | 0                 | 0                         |
| Нийт (Улс) |                | Тоо  | 80,600            | 112,910.77         | 100,334.98        | (0.77)                    |
|            |                | Дүн  | 7,615.5           | 10,349.12          | 8,235.98          | 0.16                      |

Хүснэгт 5. Төлбөрийн картаас бусад хэрэгсэл ашиглан банкны салбар дээр хийгдсэн гүйлгээний тайлан - Илгээсэн гүйлгээ

01/01/2020 - 31/03/2020 (мянган ширхэг, тэрбум төгрөг)

| Гүйлгээний төрөл     | Бэлэн мөнгө |          | Кредит шилжүүлэг |           | Гуйвуулга     |      |           |       |                        |      | Гадаад шилжүүлэг<br>(SWIFT) |          | Нийт      |           |
|----------------------|-------------|----------|------------------|-----------|---------------|------|-----------|-------|------------------------|------|-----------------------------|----------|-----------|-----------|
|                      |             |          |                  |           | Western Union |      | Moneygram |       | Бусад мөнгөн гуйвуулга |      |                             |          |           |           |
|                      | Тоо         | Дүн      | Тоо              |           | Тоо           | Дүн  | Тоо       | Дүн   | Тоо                    | Дүн  | Тоо                         | Дүн      | Тоо       | Дүн       |
| Илгээсэн гүйлгээ     | 4,298.81    | 5,055.23 | 18,469.19        | 34,460.67 | 1.30          | 1.94 | 1.83      | 3.88  | 5.97                   | 8.81 | 45.20                       | 8,451.43 | 22,822.30 | 47,981.97 |
| Хүлээн авсан гүйлгээ | 3,445.65    | 4,632.69 | 0.00             | 0.00      | 6.02          | 9.11 | 14.07     | 21.14 | 6.64                   | 8.05 | 46.13                       | 4,790.18 | 3,518.53  | 9,461.17  |

Хүснэгт 6а. Төлбөрийн картын залилангийн гүйлгээ - Картын төрлөөр

01/01/2020 - 31/03/2020 (мянган ширхэг, тэрбум төгрөг)

| № |     | Өөрийн гаргасан карт |      |            |          |       |         | Дотоодын бусад банкны гаргасан карт |      |            |          |       |         | Гадаадын байгууллагын гаргасан карт |            |          |       |         | Нийт |
|---|-----|----------------------|------|------------|----------|-------|---------|-------------------------------------|------|------------|----------|-------|---------|-------------------------------------|------------|----------|-------|---------|------|
|   |     | ₮ карт               | Виза | Мастеркарт | ЮнионПэй | Амекс | ЖейСиБи | ₮ карт                              | Виза | Мастеркарт | ЮнионПэй | Амекс | ЖейСиБи | Виза                                | Мастеркарт | ЮнионПэй | Амекс | ЖейСиБи |      |
| 1 | Тоо | 0.02                 | 0.17 | 0.00       | 0.01     | 0.00  | 0.00    | 0.02                                | 0.01 | 0.00       | 0.01     | 0.00  | 0.00    | 0.00                                | 0.00       | 0.00     | 0.00  | 0.00    | 0.23 |
| 2 | Дүн | 0.00                 | 0.15 | 0.01       | 0.00     | 0.00  | 0.00    | 0.00                                | 0.00 | 0.00       | 0.00     | 0.00  | 0.00    | 0.00                                | 0.00       | 0.00     | 0.00  | 0.00    | 0.18 |

Хүснэгт 6б. Төлбөрийн картын залилангийн гүйлгээ - Төхөөрөмжийн төрлөөр

01/01/2020 - 31/03/2020

| №    | Байршил    | Төхөөрөмж      | Тоо | Дүн            |
|------|------------|----------------|-----|----------------|
| 1    | Монгол улс | ПОС            | 19  | 2,063,655.06   |
| 2    |            | МПОС           | 5   | 487,070.00     |
| 3    |            | АТМ/CRM        | 32  | 9,882,500.00   |
| 4    |            | Цахим худалдаа | 8   | 2,956,305.27   |
| 5    | Олон улс   | ПОС            | 49  | 145,025,505.55 |
| 6    |            | АТМ/CRM        | 8   | 2,324,842.33   |
| 7    |            | Цахим худалдаа | 112 | 12,953,184.92  |
| Нийт |            |                | 233 | 175,693,063.13 |

Хүснэгт 6в. Төлбөрийн картын залилангийн гүйлгээ - Төхөөрөмжийн төрлөөр

2018 - 2020 он (сая төгрөгөөр)

| Он                      | Утга | ПОС    | АТМ/СRМ | Цахим худалдаа | Бусад | Нийт  |
|-------------------------|------|--------|---------|----------------|-------|-------|
| 2018 он, I улирал       | Тоо  | 73     | 16      | 2              | 0     | 91    |
|                         | Дүн  | 10.2   | 7.3     | 0.6            | 0     | 18    |
| 2019 он, I улирал       | Тоо  | 9      | 83      | 46             | 2     | 140   |
|                         | Дүн  | 20.6   | 17.7    | 6.9            | 1.7   | 46.9  |
| 2020 он, I улирал       | Тоо  | 68     | 40      | 120            | 5     | 233   |
|                         | Дүн  | 147.09 | 12.21   | 15.91          | 0.49  | 1,757 |
| Өсөлт/бууралт (2019-IV) | Тоо  | 31.8   | 20      | 80.9           | (100) | 57.9  |
|                         | Дүн  | 3026.7 | (3.7)   | 96.7           | (100) | 188.5 |

## ТӨЛБӨРИЙН СИСТЕМИЙН ОРОЛЦОГЧ ХООРОНДЫН ГҮЙЛГЭЭ

Хүснэгт 7. Их, бага дүнтэй гүйлгээний тоо, дүн

2018-2020 он (мянган ширхэг, их наяд төгрөг)

|             | 2018 он   |       |       |      | 2019 он <sup>6</sup> |        |       |       | 2020 он   |      |       |      |
|-------------|-----------|-------|-------|------|----------------------|--------|-------|-------|-----------|------|-------|------|
|             | тоо       | %     | дүн   | %    | тоо                  | %      | дүн   | %     | тоо       | %    | дүн   | %    |
| I улирал    | 9,295.8   | 32.2  | 20.0  | 46.5 | 13,021.6             | 40     | 69.1  | 245.5 | 12,920.10 | -0.8 | 67.20 | -2.7 |
| Бага дүнтэй | 8,808.8   | 32.3  | 1.2   | 44.0 | 12,727.4             | 44.5   | 2.5   | 108   | 12,599.90 | -1.0 | 3.05  | 22.0 |
| Их дүнтэй   | 487.0     | 29.2  | 18.8  | 46.8 | 294.2                | -39.58 | 66.6  | 254.2 | 320.20    | 8.8  | 64.15 | -3.7 |
| II улирал   | 10,992.3  | 45.9  | 22.8  | 15.2 | 14,856.3             | 35.2   | 78.2  | 242.8 |           |      |       |      |
| Бага дүнтэй | 10,379.7  | 47.0  | 1.4   | 48.4 | 14,474.4             | 39.4   | 3.05  | 117.9 |           |      |       |      |
| Их дүнтэй   | 612.6     | 29.8  | 21.4  | 13.0 | 381.9                | -37.7  | 75.1  | 250.9 |           |      |       |      |
| III улирал  | 10,850.6  | 117.0 | 19.7  | 13.6 | 15,114               | 39.3   | 74.1  | 276.1 |           |      |       |      |
| Бага дүнтэй | 10,232.2  | 126.3 | 1.4   | 65.5 | 14,727.2             | 43.9   | 3.2   | 128.6 |           |      |       |      |
| Их дүнтэй   | 618.4     | 29.4  | 18.2  | 11.1 | 386.8                | -37.5  | 70.9  | 289.6 |           |      |       |      |
| IV улирал   | 12,898.7  | 98.0  | 27.7  | 38.5 | 17,532.4             | 35.9   | 87.6  | 216.3 |           |      |       |      |
| Бага дүнтэй | 12,311.6  | 107.3 | 2.1   | 90.9 | 17,099.4             | 38.9   | 3.7   | 76.1  |           |      |       |      |
| Их дүнтэй   | 587.1     | 1.9   | 25.6  | 34.7 | 433.0                | -26.3  | 83.9  | 227.8 |           |      |       |      |
| Нийт        | 44,037.40 | 68.8  | 90.16 | 27.3 | 60,524.3             | 37.4   | 309.0 | 242.7 |           |      |       |      |
| Бага дүнтэй | 41,732.27 |       | 6.08  |      | 59,028.4             |        | 12.4  |       |           |      |       |      |
| эзлэх хувь  | 95.0      |       | 7.0   |      | 97.5                 |        | 4.0   |       |           |      |       |      |
| Их дүнтэй   | 2,305.13  |       | 84.03 |      | 1,495.9              |        | 296.5 |       |           |      |       |      |
| эзлэх хувь  | 5.0       |       | 93.0  |      | 2.5                  |        | 96.0  |       |           |      |       |      |

<sup>6</sup> Өмнөх тайлангуудад их дүнтэй гүйлгээний тоон мэдээг оруулахдаа зөвхөн арилжааны банкуудын дамжуулсан гүйлгээний тоон мэдээг оруулдаг байсан бөгөөд 2019 оны I улирлаас эхлэн Монголбанкны өөрийн дамжуулсан гүйлгээний тоон мэдээг оруулах болсонтой холбоотойгоор дүнгийн хувьд огцом өссөн үзүүлэлттэй байна.